



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/1093

Улаанбаатар хот

Балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78 дугаар 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 95 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар, Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсийн балансад бүртгэлтэй, нийт 109,580,388.90 (нэг зуун есөн сая таван зуун наян мянга гурван зуун наян найман мянган төгрөг ерэн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 2 барилгыг хавсралтын дагуу балансаас балансад шилжүүлэн, данс бүртгэлээсээ хасахыг Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц), Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс (Б.Эрдэнэбилэг)-т тус тус зөвшөөрсүгэй.

2.Балансаас балансад шилжин ирж буй хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлдээ бүртгэн авч, өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв (Х.Ганбат), Багануур дүүргийн Гүн галуутай цогцолбор сургууль (Б.Алтансарнай)-д тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



1110204631

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
сарын 19-ны өдрийн
захирамжийн
хавсралт



БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл (2023.06.01)	Үлдэх өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	2 дугаар хорооны хуучин барилга	БХД, 2-р хороо	2003	ш	1	76,971,582.8	8,246,955.06	68,724,627.74	Багахангай дүүргийн ЗДТГ	Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв
2	Авто гражийн барилга	БНД, 1-р хороо	1986	ш	1	32,608,806.10	2,445,660.54	30,163,145.56	Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс	Нийслэлийн ерөнхий боловсролын Гүн галуутай цогцолбор сургууль
Дүн						109,580,388.9				